

БАТЛАВ.

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ

Б.ГУРСОРОНЗОН

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 02-р сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

1. Үндэслэл

Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 хэсэгт "Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг зохион байгуулах" гэж автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхийг тодорхойлсон.

Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17¹.2 хэсэгт "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасан.

Дээр дурдсан заалтын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/222 дүгээр тушаалаар "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан автотээврийн хэрэгслийн гэрчилгээний загварыг шинэчлэн баталсан.

2. Хамрах хүрээ

Энэхүү техникийн тодорхойлолтыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/222 дугаар тушаалаар баталсан автотээврийн хэрэгслийн гэрчилгээг хэвлэж нийлүүлэхэд мөрдөнө.

3. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээнд тавигдах шаардлага.

Гэрчилгээ нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- 3.1. Гэрчилгээ нь дэлгэсэн байхдаа 104 мм өргөнтэй, 240 мм урттай байна;
- 3.2. Хэвлэлийн цаас нь 245 гр/м² нягтралтай сайн чанарын гөлгөр биш, матриц принтерийн хэвлэл, гарын үсэг, тамгын тогтоц сайн байх, эзэлгээний явцад нугалаасаар тасарч урагдахгүй, чийг авахаас хамгаалагдсан байна;
- 3.3. Гэрчилгээний дэвсгэр хээ нь хуурамчаар үйлдэхээс хамгаалагдсан зураасан хээ, бичил бичвэр зэрэгсэ бүрдсэн цайвар цэнхэр өнгөтэй хэвлэмэл хуудас байна;
- 3.4. Гэрчилгээний дэлгэсэн байх хэмжээг 3 ижил хэмжээтэй нугалахаар 2 горив гаргасан, гэрчилгээний гадна талын 2/3 хэсэгт нугалааны горив өнгөртөл ламинатан бүрхүүлтэй байна;
- 3.5. Гэрчилгээний дотор болон гадна тал нь доод хормой хэсгийн саарал зурvas, үндсэн дэвсгэр өнгө, малгайн хэсэг гэсэн 3 өнгөнөөс бүрдэнэ.
- 3.6. Хормойн саарал зурvasны өргөн 8 мм байна.

- 3.7. Үндсэн дэвсгэр өнгө нь хормойн хэсгийн саарал зүрвастай залгаа байх ба дээд талаараа малгайн хэсэгтэй нийлнэ.
- 3.8. Үндсэн дэвсгэр өнгө болон малгайн хэсгийн нийлэх хэсэг нь долгион хэлбэртэй байна.
- 3.9. Малгайн хэсгийн өргөн хамгийн өндөр хэсэгтээ 15мм, нам хэсэгтээ 8 мм байна.
- 3.10. Малгайн хэсэг нь бүдэг цэнхэр өнгийн усан хээтэй (батлагдсан загварын дагуу) байна. Хээний өнгөний код нь Pantone Airy Blue 14-4122-той байна.
- 3.11. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ нь холограмм нууцлал, неон (UV) гэрэлд харагдах нууцлал агуулсан байна;
 - 3.11.1 нууцлал нь: МОНГОЛ УЛС АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ, гэсэн үгүүдийг дараалуулан бичигдсэн бичиглэл байна.
 - 3.11.2 нууцлал үг нь гэрчилгээний малгайн хэсэгт бичигдэнз.
- 3.12. Гэрчилгээний нүүрэн талд 35x17 мм хэмжээтэй Төрийн соёмбыг шаргал өнгөөр, дээд ирмэгээс 20 мм зйтай, хоёр талаасаа ижил хэмжээний зайд голлуулан хэвлэсэн байна;
- 3.13. Гэрчилгээний нугалагдсан хэсэг бүрт 55x27 мм хэмжээтэй төрийн соёмбыг доод ирмэгээс 20 мм зайд (гадна нүүр талын хэсгээс бусад 5 талбарт) байрлуулан нууцлалтай хэвлэсэн байна;
- 3.14. Нууцлал нь хуурамчаар үйлдэхээс хамгаалагдсан байх бөгөөд нэмэлт нууцлалтай байж болно;
- 3.15. MGL тэмдэглэгээ нь:
 - 3.15.1 гэрчилгээний нүүрэн талын эхний хэсэгт доод ирмэгээс 15 мм, хоёр талдаа ижил хэмжээний зайд голлуулсан хэмжээнд,
 - 3.15.2 мөн гэрчилгээний дотор талын төв хэсгийн бичвэрийн дээр голлуулан дээд ирмэгээс 6 мм зайд хар өнгөөр хэвлэгдсэн байна.
- 3.16. Гэрчилгээний дугаарлалт захиалагчаас өгсөн хязгаараас хойш үргэлжилсэн байна.
- 3.17. Гэрчилгээний дугаар нь 8 оронтой тоогоор, гадна нүүрэн талд доод ирмэгээс 5 мм, хоёр талаасаа ижил хэмжээний зайд, мөн гэрчилгээний дотор талын төв хэсгийн бичвэрийн дор голлуулан улаан өнгөөр хэвлэгдсэн байна;
- 3.18. Гэрчилгээний үндсэн дэвсгэр нь түмэннасан хээ бүхий пантон өнгөний систем /Pantone Color Systems/-ийн Pantone 2915 U өнгөтэй байх ба дугуй хэлбэртэй гильош хээ (батлагдсан загварын дагуу), түүний доторх соёмбо (55x27 мм), хормойн доод саарал зуравс нь Pantone cool gray 5U (зуравсны өргөн 8 мм), нүүрэн хэсэг дэх шаргал соёмбо нь (35x17 мм) 871U pantone зэрэг өнгөнүүдтэй байна.
- 3.19. Гильош хээ нь 6 талбар тус бүрт байх бөгөөд гаднах хүрээ нь доод ирмэгээс 15 мм, баруун болон зүүн талаасаа /3 тэнцүү хэмжээтэй хуваасан нугалаасны захаас/ 5 мм, дээд ирмэгээс 25 мм хэмжээтэй байна.

- 3.20. Гэрчилгээний гадна болон дотор талын гильош хээ нь хэлбэрийн хувьд ижил, гэрэл нэвтрүүлэн шалгахад давхцаж байвал зохино.
4. Гэрчилгээний тоо ширхэг, сав, боодол
- 4.1 Тоо хэмжээ 600,000 ширхэг
 - 4.2 Гэрчилгээг 100 ширхэг бүрээр нэг боодол болгон, 10 боодлыг нь нэг багц боодол /1000 ширхэг/ болгон савлана.
 - 4.3 Гэрчилгээний багц бүрийг тоос шороо, чийг нэвтрэхгүй цаасаар боох бөгөөд боодол бүрийн гадна талд сар бүрийн тэмдэглэгээ хийсэн байна.
5. Гэрчилгээнд бичигдэх мэдээлэл. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
- 5.1 Гэрчилгээний дотор талын (батлагдсан загварын дагуу), 3 хуваагдсан хэсгийн эхний талбарт:
 - 5.1.1. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ (1 мэр);
Technical specifications (1 мэр);
 - 5.1.2. Улсын дугаар (1 мэр);
Registration plate number (1 мэр);
 - 5.1.3. Марк, загвар (1 мэр);
Make, model (1 мэр);
 - 5.1.4. Ангилал, хөдөлгүүрийн багтаамж (1 мэр);
Category, engine displacement (1 мэр);
 - 5.1.5. Бүх жин (1 мэр);
Gross vehicle weight (1 мэр);
 - 5.1.6. Даац, суудлын тоо (1 мэр);
Loading capacity, number of seats (1 мэр);
 - 5.1.7. Төрөл (1 мэр);
Type (1 мэр);
 - 5.1.8. Зориулалт (1 мэр);
Vehicle designation (1 мэр);
 - 5.1.9. Арлын дугаар (1 мэр);
Chassis number (1 мэр);
 - 5.1.10. Бүхээгийн № (1 мэр);
Cabin number (1 мэр);

Гэрчилгээний дотор тал, 3 хуваагдсан хэсгийн голд буюу MGL тэмдэглэгээний доод талд:

- 5.1.11. Хөдөлгүүрийн дугаар (1 мэр);
Engine number (1 мэр);
- 5.1.12. Үйлдвэрлэсэн он (1 мэр);
Year of manufacture (1 мэр);
- 5.1.13. Импортолсон огноо (1 мэр);
Date of Importation (1 мэр);
- 5.1.14. Өнгө (1 мэр);
Color (1 мэр);
- 5.1.15. Тэнхлэгийн тоо (1 мэр);
Axes (1 мэр);
- 5.1.16. Улсын бүртгэлийн дугаарын өнгө (1 мэр);

- Color registration plate number (1 мөр);
5.1.17. Өмчлөгч (1 мөр);
 Owner (1 мөр);
- 5.1.18. Өмчлөгчийн нэрийг дэлгэрэнгүй бичих боломжтой 2 мөр
 бүхий бичиглэлгүй хүснэгт
- 5.1.19. Хаяг (1 мөр);
 Address (1 мөр);
- 5.1.20. Өмчлөгчийн хаягийг дэлгэрэнгүй бичих боломжтой 2 мөр
 бүхий бичиглэлгүй хүснэгт.

Гэрчилгээний дотор тал, 3 хуваагдсан хэсгийн сүүлийн талбарт:

- 5.1.21. ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА(1 мөр);
 CERTIFICATE ISSUING AUTHORITY (1 мөр);

Хоёр талаасаа ижил зайд голлуулсан байх ба гэрчилгээ олгосон
бүртгэлийн байгууллагын нэрийг бүтнээр нь, ойлгомжтой байдлаар бичих
боломж бүхий талбартай байна.

- 5.1.22. Бүртгэлийн ажилтан (1 мөр);
 Registration officer (1 мөр); 5.1.14-ийн харалдаа байрлалд,
- 5.1.23. Тэмдэг (1 мөр);
 Stamp (1 мөр);
- 5.1.24. Гарын үсэг (1 мөр);
 Signature (1 мөр);
- 5.1.25. Он..... сар..... өдөр (1 мөр);
 YYYY.....MMDD (1 мөр); (Огноог 2 талаас ижил
хэмжээний зайд голлуулсан байна).
- 5.1.26. Тусгай тэмдэглэл (1мөр)
Additional note (1мөр), 5.1.18-хааралдаа байх ба доод
талдаа 3-4 мөр бүхий бичиглэл хийх боломж бүхий орон
зайтай байна/
- 5.2. 5.1.1-5.1.31 мөрүүд нь батлагдсан загварын дагуу англи хэл дээр
орчуулсан орчуулгатай байна.
- 5.3. Гэрчилгээний гадна талын хэсэгт:
Эхний талбарын дээд талд:
- 5.3.1. “МОНГОЛ УЛС” (1 мөр).
MONGOLIA (1 мөр), 2 талаасаа ижил зайд,
- 5.3.2. эхний нүүрэнд “АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ” гэсэн бичвэрийн дээд талд франц хэл дээрх
орчуулга (CERTIFICAT D'IMMATRICULATION DU
VEHICULE), доод талд нь англи хэл дээрх орчуулга
(CERTIFICATE OF VEHICLE REGISTRATION), (2 талаасаа
ижил хэмжээний зайд батлагдсан загварын дагуу);
- 5.3.3. гэрчилгээний гадна талын дунд хэсгийн голд MGL
тэмдэглэгээ.
- 5.3.4. MGL-ийн доод “САНАМЖ” бичиглэл байна.

- 5.3.5. "САНАМЖ" бичиглэлийн доор "АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ӨМЧЛӨГЧ ТА: гэсэн бичиглэл байна.
- 5.3.6. "АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ӨМЧЛӨГЧ ТА: гэсэн бичиглэлийн доор "САНАМЖ"-ийг бичвэр хэлбэрээр бичсэн байна. (батлагдсан загварын дагуу);
- 5.3.7. гэрчилгээний гадна талын гурав дахь хэсэгт техникийн хяналтын үзлэгийн тэмдэглэл (батлагдсан загварын дагуу, хүснэгтээр байх багаад мөр бүрийн доор англи хэл дээр орчуулсан орчуулгатай байна);
- 5.3.8. энэхүү талбарын зүүн доод буланд:
Засвартай бол хүчингүй(1 мөр)
Not valid if edited (1 мөр) бичиглэл зэрэг шаардлагуудыг хангасан байна.

Автотээврийн хэрэгслийн гэрчилгээний загвар, өнгөний кодыг хавсаргав.
(Хавсралт 2 хуудастай)


Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 06 сарын 25-ны өдрийн 219
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Автотээврийн хэрэгслийн гэрчилгээний загвар

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ Technical specifications		MGL	ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛАГА Certificate issuing authority
Улсын бүртглийн дугаар Registration plate number		Хөдөлгүүрийн дугаар Engine number	
Марк, загвар Make, model		Түүхээрхийн он Year of manufacture	
Ангилаал, хадалгүүрийн багтавмын Category, engine displacement		Импортолсон ондоо Date of importation	
Бүх жин Gross vehicle weight		Бие Color	
Дэвсүүц, суудлын тоо Loading capacity, number of seats		Танклагийн тоо Axles	
Төрөл Type		Улсын бүртглийн дугаарын онгоц Color registration plate number	
Зорилтуулт Vehicle designation		Бичигч Signer	
VIN дугаар, VIN number		Тусгай тэмдэглэл Additional note	
Аргамын дугаар, Chassis number		Хаяг Address	
Бүхэлжийн дугаар, Serial number		№ 00000000	

ТЕХНИКИЙН ХЭНТЭЭЛТИЙН УЗЛЭГ TECHNICAL INSPECTION			MGL	МОНГОЛ УЛС MONGOLIA
Он. Сар. Өдөр YYYY-MM-DD	Техникийн байдал Technical status	Гарын усаг Тэмдэг Signature Stamp	САНМОЖ	АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ӨМЧИЛГЭЧ TA:
			<ul style="list-style-type: none"> ❖ Шинээр автотээврийн хэрэгсэл өмчилж, зөвсөн бол 72 цагийн дотор; ❖ Ашиглалтавас хөссөн бол 1 сарын дотор; ❖ Нар, хаяг, арлын болон хадалгүүрийн дугаар, онгоц барилгасан бол 7 хоногийн дотор тус тус бүртгүүлэх; ❖ Жолочийн хариуцлагын давтгэлд хамрагдаж; ❖ Хуульд зөвсөн хутсаанд албан татвараар төлөх; ❖ Тогтоосон хутсаанд техникийн хийнчилгээнд хамрагдаж, түүхийн үзүүлж хамгуулж хурагжсан. 	
Зөсөвартай бол хүчинсүй Not valid if edited			 CERTIFICAT D'IMMATRICULATION DU VÉHICULE АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ CERTIFICATE OF VEHICLE REGISTRATION № 00000000	

ӨНГӨНИЙ КОД



PANTONE 2915U



PANTONE®
Airy Blue 14-4122

CMYK 48 21 10 0
RGB 146 162 213
HTML #2E3355



PANTONE
871 U



PANTONE
Cool Gray 5 U

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хуртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	Тээврийн хэрэгслийн гэрчилгээ	600,000	ширхэг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Ариг банкны байр	2024.05.05-2024.06.05	
2						
3						
...						